



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/249

Номгон

Онцгой нөхцөл байдалд ажиллаж байгаа төрийн
албан хаагч болон зорилтот бүлгийн иргэдийг
коронавирусын халдвараас сэргийлэх
дархлаажуулалтад хамруулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 133 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/02, А/235 тоот захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 34 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын хүрээнд халдварын голомтын бүс болон өндөр эрсдэл бүхий онцгой нөхцөлд ажиллаж байгаа холбогдох чиглэлийн байгууллагуудын ажилтан албан хаагчид, голомтын бүсэд байгаа зорилтот иргэдийг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 09-ний өдөр хүртэл 5 хоногийн хугацаанд урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулсугай.

2. Эхний ээлжийн дархлаажуулалтыг эхлүүлэхтэй холбогдуулан ерөнхий боловсролын Номундалай, Эрдэнэмандал ахлах сургуулийн спорт заалуудад нэгдсэн дархлаажуулалт зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж, стандартын шаардлагад нийцсэн байр бэлтгэж, дархлаажуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж)-г;

3. Улаанбаатар хотоос дархлаажуулалтын вакцин холбогдох норм, дүрэм, журмын дагуу тээвэрлэж, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангаж, аймгийн Эрүүл мэндийн газарт хүлээлгэн өгөх ажлыг хариуцан зохион байгуулахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-д;

4. Эхний ээлжинд дархлаажуулалтад хамруулах холбогдох байгууллагын ажилтан, алба хаагч болон иргэдийн судалгааг гаргаж, эрэмбэлэн ангилж,

621010001

2.

дархлаажуулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж ажиллахыг Тагнуулын хэлтэс (дэд хурандаа Р.Мэндбаяр)-т;


5. Онцгой нөхцөлд ажиллаж байгаа төрийн албан хаагч, иргэдийг халдвар хамгааллын дэглэм баримтлуулан, хариуцлагын өндөр төвшинд зохион байгуулж, дүнг аймгийн Онцгой комиссын хуралд танилцуулахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-т нарт тус тус үүрэг болгосугай.

6. Дээрх үйл ажиллагаатай холбогдон гарах 3,566,240 (Гурван сая таван зуун жаран зургаан мянга хоёр зуун дөчин) төгрөгийн зардлыг аймгийн Онцгой комиссын Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн мөнгөн хөрөнгийн зардлаас шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.


8.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Онцгой комиссын даргын 2021 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 05 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын
08-ны өдрийн А/249 дүгээр захирамжийн хавсралт



**ЭХНИЙ ЭЭЛЖНИЙ ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДАГДАХ ЗАРДЛЫН
ТООЦОО**

Д/д	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо /км	Мөнгөн дүн
1	2	3	4	5
1	Тээвэрлэлтийн шатахууны зардал	А-92 1560	2800 2 машин 504 л	786.240
2	Цэвэр ус /баллонтой/	20.000 баллонтой 5.000 ширхэг	Б-4 Ш-40	280.000
3	Хоол, хуурай хүнсний зардал	40 хүн 2 цэг Өдрийн нэг хоол	10 хоног 50 хоол 1 хоол 5000 хоргүйжүүлэх хүнс	2,500,000
4	Нийт			3,566,240

-----000-----